




2026 оны 8 дугаар сарын 11-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Дэлхийн болон Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, гадаад, дотоод орчны тодорхой бус байдал нэмэгдэн, иргэдийн орлого, амьжиргаанд үзүүлэх дарамтыг бууруулах, хүнс, эрчим хүчний хангамжийн тогтвортой байдлыг хангах, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийг тэргүүлэх ач холбогдол бүхий арга хэмжээнд чиглүүлэх шаардлага үүсээд байна.

Иймд 2026 оны төсвийн жилийн үлдсэн хугацаанд төсвийн хөрөнгийг зайлшгүй шаардлагатай, нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий арга хэмжээнд төвлөрүүлж, иргэдийн орлого, амьжиргааг хамгаалах, хүнс, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, төсвийн сахилга бат, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төсвийн орлого, зарлага, санхүүжилтийн эх үүсвэр болон төсөв зарцуулах эрхийн зохицуулалтад холбогдох өөрчлөлт оруулах практик шаардлага бий болж байна.

Нэгдүгээрт, стратегийн бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх:

Шатахуун, мах, гурил, хүнсний ногоо зэрэг стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний нийлүүлэлт, үнэ, хангамжийн тогтвортой байдалд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан нөөц бүрдүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна. Иймд стратегийн бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, хадгалах, нийлүүлэлтийг тогтворжуулах арга хэмжээнд шаардлагатай төсвийн эх үүсвэрийг чиглүүлэх нь зүйтэй.

Хоёрдугаарт, иргэдийн орлого, амьжиргааг хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх:

Нийгмийн даатгалын тухай хуульд заасан зохицуулалтын хэрэгжилтийг наашлуулж, ахмад настанд олгох суурь тэтгэврийг 2026 оны 11 дүгээр сараас эхлэн олгох, мөн эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин хөлсийг 20 хувь, соёл, спорт, цаг уур зэрэг төрийн үйлчилгээний бусад салбарын ажилтнуудын цалин хөлсийг 50 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах шаардлагатай байна. Энэ нь иргэдийн худалдан авах чадвар, орлогын тогтвортой байдлыг хамгаалах, нийгмийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэнэ.

Гуравдугаарт, эрчим хүчний салбарын найдвартай ажиллагаа, хэрэглэгчдэд үзүүлэх санхүүгийн дарамтыг бууруулах:

Эрчим хүчний үнэ, тарифын өсөлтөөс хэрэглэгчдэд үүсэх дарамтыг бууруулахын зэрэгцээ эрчим хүчний системийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор станц, компаниудын зайлшгүй шаардлагатай засвар, шинэчлэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах арга хэмжээг санхүүжүүлэх шаардлага бий болсон.

Дөрөвдүгээрт, төсвийн үр ашиггүй болон зайлшгүй бус зардлыг бууруулж, хэмнэсэн эх үүсвэрийг тэргүүлэх чиглэлд шилжүүлэх:

Гадаад томилолт, тавилга, эд хогшил худалдан авах, зочин төлөөлөгч хүлээн авах, засвар хийх, багаж, техник хэрэгсэл худалдан авах зэрэг зайлшгүй бус зардлыг 2026 оны үлдсэн хугацаанд хязгаарлаж, хэмнэсэн эх үүсвэрийг иргэдийн орлого, амьжиргааг хамгаалах, хүнсний болон бусад зайлшгүй шаардлагатай арга хэмжээнд чиглүүлэх шаардлагатай байна.

Тавдугаарт, төсвийн санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн өмчит байгууллагын бие даасан байдлыг дээшлүүлэх:

Үйл ажиллагааны зардлаа өөрийн орлогоороо бүрэн санхүүжүүлэх боломжтой улсын төсөвт үйлдвэрийн газрыг төсвийн санхүүжилтээс үе шаттайгаар гаргаж, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төрийн өмчит

компани, үйлдвэрийн газруудын бүтэц, зохион байгуулалтыг оновчлох, давхардсан чиг үүргийг арилгах, үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар төсвийн зардлын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Зургаадугаарт, төрийн өмчит компанийн хөрөнгийн өгөөж, төсөвт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх:

Төрийн өмчит компаниудын засаглал, ашигт ажиллагаа, санхүүгийн сахилга батыг сайжруулж, улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг нэмэгдүүлэх, төрийн өмчит компанийн хувьцаа, хөрөнгийн удирдлагыг олон улсын сайн туршлагад нийцүүлэн боловсронгуй болгох, шаардлагатай тохиолдолд хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд санал болгох бэлтгэл ажлыг хангах хэрэгцээ байна. Үүнтэй уялдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Иймд дээр дурдсан нийгэм, эдийн засгийн зайлшгүй шаардлагаар төсвийн нөөцийг тэргүүлэх чиглэлд үр ашигтай хуваарилах, иргэдийн орлого, амьжиргааг хамгаалах, стратегийн бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга бат болон төрийн өмчит байгууллагын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийж, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хуулийн төсөлд 2026 оны төсвийн жилд төвлөрүүлэх нийт орлого, зарцуулах хэмжээ, хөрөнгө ба өрийн удирдлага, улс болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг болон бусад зохицуулалттай холбогдсон харилцааг тусгасан 4 зүйл, 1 хавсралттай байхаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн нөөцийг нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлж, иргэдийн орлого, амьжиргааг хамгаалах, стратегийн бүтээгдэхүүн болон эрчим хүчний хангамжийн тогтвортой байдлыг хангах, төсвийн зарлагын үр ашиг, сахилга батыг нэмэгдүүлэх эдийн засаг, нийгмийн эерэг үр дагавар бий болно.

Тухайлбал, ахмад настанд суурь тэтгэвэр олгох хугацааг наашлуулж, төрийн үйлчилгээний салбарын ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлснээр өрхийн орлого, худалдан авах чадварыг дэмжих, стратегийн бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлснээр хүнсний болон шатахууны хангамжийн эрсдэлийг бууруулах, эрчим хүчний салбарын засвар, шинэчлэлийг эрчимжүүлснээр найдвартай ажиллагааг хангах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсруулна.

---o0o---